

Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл						
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам						
2025 оны хагас жил						
Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2025 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн
4. ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ						
1	4.2. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	4.2.5. Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-		2025 онд: 1. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн 2024 оны 03 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн хуулийн 11.7, 13.4-т заасан "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам" болон "Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам"-ын төслүүдийг тус тус боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т 2025 оны 01/1360 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2. "Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффис байгуулах ТЭЗҮ, зураг төслийг хийж гүйцэтгэх" хүрээнд бүс болгонд байгуулахтай холбоотой судалгааны эхлэлийн тайланг хийж, ЦХИХХ-ны сайдын 2025 оны А/80 дугаар тушаалаар хаб байгуулах бүсийн байршлыг тогтоосон. Үүний дагуу тодорхойлогдсон бүсэд хамаарах 6 аймгаас хаб байгуулах байршлын мэдээллийг авч, холбогдох нарийвчилсан судалгаа, техникийн зургийг боловсруулж байна. 3. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар 855 сервисийг Төрийн мэдээлэл солилцооны систем (www.xyp.gov.mn)-ээр дамжуулан солилцож, төрийн 173, хувийн 465, нийт 638 байгууллага, Танилт, нэвтрэлтийн нэгдсэн систем (ДАН)-д төрийн 98 байгууллагын 188, хувийн 276 байгууллагын 325 систем, нийт 374 байгууллагын 513 систем бүртгэлтэй 2,220,683 иргэн байна.
5. ТАВ. ЗАСАГЛАЛ						

2	5.3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ.	5.3.1. Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, хүн амыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбоно.	2021 - 2025	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан - 842.1		1. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 6-д заасан “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх”, 7-д заасан “сурч боловсрох эрх”, 8-д заасан “бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрх”, 12-д заасан “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх”, 17-д заасан “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрх”-ийг хангах зорилгоор Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтээр “Гэр хорооллын бүсэд өндөр хурдны интернэтийн үйлчилгээ хүргэх” төслийн хүрээнд 2023 онд Баянзүрх дүүргийн 28 дугаар хорооны 1000, Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны 1092, Чингэлтэй дүүргийн 14, 16, 18 дугаар хорооны 760, Говь-Алтай аймгийн Дарви сумын 219, Тайшир сумын 101, Булган аймгийн Дашинчилэн сумын 328, нийт 3500 өрхөд өндөр хурдны интернэтийн үйлчилгээг холбож хүргэсэн. Мөн Хөвсгөл, Ховд, Дорнод, Архангай, Баянхонгор аймгийн алслагдсан 15 багт үүрэн холбооны 4G сүлжээ нэвтрүүлж, нийт 10 мянга орчим иргэн өндөр хурдны хөдөлгөөнт интернэтэд холбогдох, төрийн цахим үйлчилгээ, мэдээ, мэдээлэлийг шуурхай авах, аялагч амрагчид харилцаа холбооны бусад үйлчилгээг саадгүй, шуурхай авах боломжийг бүрдүүлсэн. 2. Монгол Улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5G технологид ашиглах радио давтамжийн тусгай зөвшөөрлийг олгох сонгон шалгаруулалтыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос зохион байгуулж, 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хөдөлгөөнт холбооны үйлчилгээ эрхлэгч 5 операторт радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийг олгосноор Монгол Улсад албан ёсоор 5G технологийг нэвтрүүлсэн.
3		5.3.2. Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болгож хөгжүүлэх нэгдсэн бодлого, төлөвлөлттэй болгоно.	2021 - 2025	-		1.Үндэсний дата төв (УТУГ)-ын үйл ажиллагааг олон улсын дата төвийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн клауд (PAAS-Platform as a Service) хэлбэрт шилжүүлсэн. 2025 оны нэгдүгээр сараас эхлэн шинээр ирүүлж буй систем байршуулах хүсэлтүүдийг “Mcloud” систем дээр байршуулан ажилласан. Нийт 168 зохиомол сервер шинээр үүссэн. 2.“Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгэл хөтлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан журам”-ыг Засгийн газрын 2024 оны 77 дугаар тогтоолыг батлуулсан. Тогтоолын хүрээнд Үндэсний статистикийн хороотой хамтран мэдээлэл хариуцагч байгууллагын мэдээллийн сан, тэдгээрийн их өгөгдлийн санд нэгтгэх суурь нөхцөлийн бэлэн байдлын үнэлгээ, мэдээллийн сангийн мета-өгөгдлийн судалгааны өгөгдөл, Хүн ам, өрхийн бүртгэлийн сан, Статистикийн бизнес регистрийн сан, Мал тооллогын мэдээллийн сангийн мэдээллийг агуулсан "Мета-өгөгдлийн платформ" хөгжүүлж, 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хэрэглээнд нэвтрүүлсэн. 3.Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд 2022 онд 3, 2023 онд 15, 2024 онд 9, 2025 оны эхний хагас жилд 9, нийт 36 зөвлөмж, дүгнэлт гаргасан. 4.Их өгөгдлийн (big data) сан үүсгэх тухай” 3Г-ын 2023 оны 403 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд: -Мэдээлэл хариуцагч 24 байгууллагын 44 мэдээллийн сангийн мета-өгөгдлийн үзүүлэлтүүдээс хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлох, хязгаарлалттай мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох арга, мэдээллийг Төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулах шийдэл зэрэг судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 5. Энэхүү платформд 56 байгууллагын үүсгэсэн өгөгдлийн багц (мэдээллийн сан) 57, хүснэгт 380, үзүүлэлт 5705, ангилал, код 747, тэдгээрийг цуглуулж буй маягт 267 байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 10 хуулийн хэрэгжилтийг тус яамнаас хангуулан ажиллаж байна.

4	5.3.3. Төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо сайжирч, захиргааны зардал бууран, үйлчилгээний үр дүн сайжирна.	2021 - 2025			1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар 855 сервисийг Төрийн мэдээлэл солилцооны систем (www.xyp.gov.mn)-ээр дамжуулан солилцож, төрийн 173, хувийн 465, нийт 638 байгууллага, Танилт, нэвтрэлтийн нэгдсэн систем (ДАН)-д төрийн 98 байгууллагын 188, хувийн 276 байгууллагын 325 систем, нийт 374 байгууллагын 513 систем бүртгэлтэй 2,220,683 иргэн байна. 2.Албан бичиг солилцооны дундын DocX системийг хөгжүүлэн Аблесофт, ерp.e-mongolia.mn, Digital office, Veritech ерp, "e-doc", ""Able"" зэрэг 17 төрлийн албан бичиг солилцооны системтэй холболт хийн 2787 байгууллагатай албан бичиг солилцох боломж бүрдсэн. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 83,812 бичгийг 121,418 хавсралттайгаар илгээж, 94,121 албан бичиг хүлээн авсан байна.
5	5.3.4. Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал нэмэгдэж, иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлнэ.	2021 - 2025			"1.Иргэдэд төрийн байгууллагаас олгодог баримт бичиг, гэрчилгээ, зөвшөөрөлтэй холбоотой төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдлийг Мэдэгдэл хүргэх систем (www.E-Mongolia.mn)-ээр дамжуулан авах боломжийг бүрдүүлж, иргэдэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 35,668,892 мэдэгдлийг хүргэсэн. Үүнээс үндэсний цахим шуудан (73.7% буюу 26,318,442), хувийн цахим шуудангийн хаяг (1.4% буюу 442,286), Push Notification (24.9% буюу 8,908,164)-ээр дамжуулан хүргэсэн. Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгож, нээлттэй, ил тод, шуурхай байлгах зорилгоор төр, иргэнийг холбосон мэдээлэл дамжуулах цахим суваг болох Үндэсний цахим шуудангийн систем (www.mail.e-mongolia.mn)-ийг нэвтрүүлж, 2 сая хэрэглэгчид мэдэгдэл хүргэх боломжийг бүрдүүлсэн. 2.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын хүрээнд иргэний мэдээлэл хайх, мэдээлэл хүлээн авах эрхийг хангах зорилгоор 67 төрлийн мэдээллийг ил тод, нээлттэй байлгах аар зохицуулсан. Мэдээлэл хариуцагч байгууллага өөрийн байгууллагын нээлттэй мэдээллийн үнэлгээг тухай бүр шинэчлэх, илгээх нөхцөлийг бүрдүүлэхээр Нээлттэй мэдээллийн систем (www.shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбар ашиглалтад нэвтрүүлсэнтэй холбогдуулан 67 нээлттэй мэдээллийг улирал бүр үнэлж ""Шилэн Индекс""-ийг тухай бүр нийтэлж байна. 2025 оны I улирлын байдлаар нийт 1,126 байгууллага мэдээллийн ил тод байдлын ""Шилэн индекс""-ийн тайланг нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ээр дамжуулан илгээсэн ба төрийн захиргааны төв байгууллага 92.61% (Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон 11 яам), төрийн захиргааны байгууллага 79.61% (23 агентлаг), Нийслэлийн Засаг даргын Тамгын газар 55.59% (6 ЗДТГ), нутгийн захиргааны байгууллага 75,84% (14 аймаг)-тай үнэлэгдээд байна. Тус системд II улирлын тайланг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хүлээн авч ажиллаж байна. Үнэлгээ хийгдэж байна.
7. ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ					

6	7.5. Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, технологид суурилсан инновац, интеграцыг хөгжүүлж, эрсдэлийн менежментийн үндэсний чадавхыг бэхжүүлнэ.	7.5.2. Мэдээлэл, технологи, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн тогтолцоо бүрдэж, технологийн хараат байдал буурч, кибер гэмт хэрэг, кибер халдлагатай тэмцэх чадавх дээшилсэн байна.	2021 - 2025			1. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн 2024 оны 03 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн хуулийн 11.7, 13.4-т заасан "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам" болон "Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам"-ын төслүүдийг тус тус боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т 2025 оны 01/1360 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2. Монгол Улсын хэмжээнд хиймэл оюуныг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, өнөөгийн нөхцөл байдал болон дэлхийн цаашдын чиг хандлагын талаар судалж "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийн төслийг боловсруулж, нийт 12 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. 4.Азийн хөгжлийн банктai хамтран "Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хөрөнгө оруулалтын стратеги боловсруулах" судалгаа, Японы хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран "Монголын харилцаа холбоо, мэдээллийн технологи ба гарааны бизнесийг хөгжүүлэх судалгаа"-г тус тус хийсэн. Олон Улсын цахилгаан холбооны байгууллагаас 2024 онд гаргасан Кибер аюулгүй байдлын индекс тодорхойлох судалгаагаар МУ-ын индексийн үзүүлэлт 2020 оныхтой харьцуулахад даруй 115 хувийн өсөлттэй байж, 193 орноос 103 дугаар байрт орсон. Төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулахад үндэсний компанийн боловсруулсан програм хангамжийг түлхүү ашиглах, төсөвт зардлыг хэмнэх зайлшгүй шаардлагыг харгалзан "Мэдээллийн технологийн программ хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай" ЗГ баталсан. Төрийн программ хангамжийн худалдан авах үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах, үргүй зардлыг бууруулах зорилгоор "Үндэсний программ хангамжийн их дэлгүүр" /Mindgolia/ системийг 2022 оны 12 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлсэн.
---	---	---	-------------	--	--	---